



НАУЧНО-ИССЛЕДОВАТЕЛЬСКИЙ ИНСТИТУТ ОБОРОНЫ МОНГОЛИИ

№ . 10 .

2020 оны 10 дугаар сарын 10

Улаанбаатар, Монгол Улс

КОМУ: ОРОСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН СИБИРИЙН САЛБАРЫН
МОНГОЛ, БУДДА, ТӨВӨД СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ,
ОРОСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН СИБИРИЙН САЛБАРЫН
БУРИАД ДАХЬ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ЭРДЭМ
ШИНЖИЛГЭЭНИЙ УДИРДАГЧ, ОРОСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИЙН АКАДЕМИЧ БОРИС ВАНДАНОВИЧ БАЗАРОВ ТАНАА

Эрхэм хүндэт Борис Ванданович!

Хүмүүний амьдралд ганцхан тохиодог их ой-насны буян хурж их мөчлөг дэлгэрэн бадарсан 60 насны тань ойн энэ өдрийг тохиолдуулан Танд монгол ёсоор юу санасан есөн цагаан хүсэл тань сэтгэлчлэн бүтэхийн өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж энэ өдрийн мэндийг хүргэе!

Монголын цэргийн эрдэмтэн судлаачид бид Таныг орчин цагийн Монгол судлалд үнэтэй хувь нэмэр оруулж буй бөгөөд Умард, Дорнод хийгээд Төв Азийн ард түмнүүдийн түүх, соёлын салбарын тэргүүлэх эрдэмтний нэг гэдгээр тань сайн мэдэх билээ.

Таны санаачилга, хоёр орны эрдэмтдийн хүсэл тэмүүллийн үр дүнд манай хоёр хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын хамтын ажиллагааны үндэс суурь тавигдаж, улам бүр өргөжин бэхжиж, Халхын голын дайн, 1945 оны Чөлөөлөх дайны сэдвээр хамтарсан томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж ирсэн хийгээд эрдэм судлалын үр шимээр бүтээгдсэн хамтын нэгэн сэдэвт судалгааны бүтээлүүдийг орос, монгол хэлээр хэвлэн нийтэлж хоёр орны уншигч түмнээ өргөн барих боломж бүрдүүлж өгч буй тань шинэ үеийн монгол цэргийн түүх судлал, түүх бичлэгт томоохон хувь нэмэр болж байгааг цохон тэмдэглэхдээ таатай байна.

Шинжлэх ухаан, судалгааны цаг наргүй, нөр их ажлынхаа хажуугаар Орос, Монгол хоёр улсын хийгээд монгол үндэстнүүд, монголч эрдэмтэн, судлаачдын хамтын ажиллагааг бэхжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж буйд тань гүн талархал илэрхийлж байна.

Буриад зоныхоо түүх-соёлын тулганд бадраасан эрдэм номын их гал тань мөнхөд бадамлан дүрэлзэж, өвгө дээдсийн буян тэгширсэн зуун насыг насалж, зургаадай таяг тулахын өлзийтэй ерөөлийг Танд өргөн дэвшүүлье!



Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал
доктор, профессор, хурандаа Б.Мөнхсайхан

УКД0288 8238316